



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ЧУХАЛ СЭДЭВ

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТЭМДЭГЛЭЛ

2022 ОНЫ 12 ДУГААР САР

“ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН 31 ДҮГЭЭР БҮЛЭГ” ТЭМДЭГЛЭЛ

АРГА ЗҮЙ

Нээлттэй Нийгэм Форум нь эрх зүйн шинэчлэлийн үйл явцыг бодлогын хэлэлцүүлэг, судалгаагаар дэмжиж ажиллахыг зорьдог билээ. Энэ хүрээнд хүний эрхэд суурилсан, шударга процесс бүхий эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор “Эрүүгийн процесс ба Хүний эрх” цуврал хэлэлцүүлгийг эхлүүлээ. Эдгээр хэлэлцүүлэг нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэд хэдэн хуулийн төслийг УИХ хэлэлцэж байгаа үетэй давхцаж буйгаараа онцлог юм. Цуврал хэлэлцүүлгийн зорилго эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шатанд тулгамдаж буй хүний эрхийн асуудлыг хөндөхөд оршиж байгаа бөгөөд хэлэлцүүлгийг ХЭҮК, ХЗДХЯ, МХХ, МӨХ-той хамтран зохион байгуулж байгаа билээ. Эхний хэлэлцүүлэг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр бүлгийн хүрээнд өрнөсөн бөгөөд түүний тэмдэглэлийг сийрүүлэн Та бүхэнд хүргэж байгаадаа баяртай байна.

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН 31 ДҮГЭЭР БҮЛЭГ

ЕРӨНХИЙ ТОЙМ

Эрүүгийн эрх зүйн шинэчлэл 1993 оноос эхэлж, энэ хугацаанд хоёр удаа эрүүгийн хууль тогтоомжийг шинэчлэн найруулж баталсан бөгөөд шинэчлэлийг гүнзгийрүүлэх ажил үргэлжлэн явагдаж байна. Энэ онд эрүүгийн хууль тогтоомжийн хүрээнд хэд хэдэн хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэж байгаа билээ. Хэдийгээр эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэх чиглэлээр тасралтгүй ажиллаж байгаа ч эдгээр хуулийн хүрээнд хүний эрхийн тулгамдсан асуудлууд орхигдсон гэх шүүмж ч хүчтэй өрнөж байна. Үүний зэрэгцээ хуульд оруулахаар хэлэлцэж буй зарим нэмэлт, өөрчлөлт хүний эрхийн зөрчил дагуулж болзошгүй мэргэжилтнүүд онцолсон. Тиймээс эдгээр асуудалд анхаарал хандуулж, холбогдох бүх талын оролцоог хангасан цуврал хэлэлцүүлэг өрнүүлэн, асуудал тус бүрээр илүү тодорхой, гүнзгий хэлэлцэж, хууль тогтоогч, хэрэгжүүлэгчдэд хандсан бодлогын зөвлөмж санал болгохыг зорьсон. Хэлэлцүүлгийн нэг онцлог бол Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэд байгуулагдсан Эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох байнгын Ажлын хэсгийн төлөөлөл оролцож байгаа явдал юм. Үүний дүнд хэлэлцэж буй асуудал хууль тогтоомжийн төсөлд тусаад явах боломжтой болно. Тус хэлэлцүүлгээр Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр хамгаалагдсан тодорхой эрхийг хөндөж ярьсан.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ, 2-р бүлэг, 16-р зүйл

13/халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ...;

14/ Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, ... эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно;

ИРГЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРХИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ПАКТ

9 дүгээр зүйл

1. Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасаж болохгүй.
2. Баривчлагдсан шалтгааныг хүн бүрд баривчлах үед нь мэдэгдэхийн зэрэгцээ буруутгаж байгаа аливаа үндэслэлийг даруй мэдэгдэнэ.
3. Баривчлагдсан буюу эрүүгийн хэрэгт буруутгагдсан аль ч хүнийг шүүгч буюу хуулийн дагуу шүүн таслах эрх хэмжээ олгогдсон бусад албан тушаалтанд даруй шилжүүлэх бөгөөд хүн хэргээ боломжийн богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх буюу суллагдах эрхтэй. Шүүхийн өмнөх шатанд байгаа хүнийг заавал цагдан хорьж байх нийтлэг журам байх албагүй бөгөөд шүүх хуралд оролцох, шүүн таслах ажиллагааны аль ч шатанд байлцах, шаардлагатай тохиолдолд, шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд байх баталгаа гаргаж өгсөн бол этгээдийг суллаж болно.
4. Баривчлагдаж, эсхүл цагдан хоригдож эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр ийнхүү хорьж саатуулсан нь хууль ёсны эсэхийг шүүхээр даруй тогтоолгох, хууль бусаар хорьсон бол суллуулах шийдвэр гаргуулах эрхтэй.
5. Хууль бусаар баривчлагдаж, эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй.

14 дүгээр зүйл

...

2. Эрүүгийн хэрэгт буруутгуулж буй хэн боловч гэм буруу нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрхтэй.
3. Хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхэд бүрэн тэгш эрхийн үндсэн дээр дараах наад захын баталгаагаар хангагдах эрхтэй:
 - (a) оногдуулж байгаа ялын шинж чанар, үндэслэлийг ойлгох хэлээр нь даруй, нарийвчлан мэдэгдэх;
 - (b) өмгөөлүүлэх ажлаа бэлтгэх хүрэлцээтэй хугацаа, бололцоотой байх, сонгож авсан өмгөөлөгчтэйгөө харилцах;

...

(d) хэргийг нь шүүхээр хянан хэлэлцэхэд байлцах, өөрийгөө биечлэн өмгөөлөх буюу өөрийн сонгон авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх; өмгөөлөгчгүй байгаа бол өмгөөлүүлэх эрхийнх нь тухай өөрт нь мэдэгдсэн байх; шүүн таслах ажлын эрх ашиг шаардаж байвал ямар ч тохиолдолд өөрт нь томилсон өмгөөлөгчтэй байх, ийм аливаа тохиолдолд өмгөөлөгчийн хөлсийг төлөх хүрэлцээтэй мөнгө хөрөнгө байхгүй бол үнэ төлбөргүй үйлчлүүлэх;

...

(g) өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, бурууг хүлээх тулган шаардалтад өртөхгүй;

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

1. Эрүүгийн хэрэгт гэрчээр дуудаж, яллагдагчаар татдаг буруу практик буюу “Сэжигтэн” хэмээх субъект ЭХХШТХ-д байхгүй гэх зөрүүтэй ойлголт

Энэ хуульд заасны дагуу баривчлагдсан, эсхүл яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүнийг сэжигтэн гэнэ.

ЭХХШТХ-ийн 31.2 дугаар зүйлийн 1

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 7.1.1-д эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг яллагдагч гэнэ хэмээн маш тодорхой заасан. Мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлээд хэн нэгнийг яллагдагчаар татах гэж байгаа бол яллагдагчаар татах тогтоолтой танилцах хүртэл “сэжигтэн” гэж нэрлэнэ. Өөрөөр хэлбэл, хэрэг бүртгэлтээс мөрдөн байцаалтад шилжих зааг дээр яллагдагчаар татах хүнийг гэрч, хохирогч гэх мэт өөр оролцогчоор нэрлэхгүй зөвхөн сэжигтэн гэнэ. Сэжигтнийг дуудан ирүүлж яллагдагчаар татах тогтоолтой танилцуулна.

“Сэжигтэн”-ийг дуудан ирүүлэх, баривчлах нь тухайн хүнийг гэмт хэрэгт буруутган, мөрдөн байцаалтыг эхлүүлж буйг мэдэгдэх үе шат юм. Өмнөх хуулийн хүрээнд байсан хүний эрхийг сэжиг таамгаар хязгаарлахыг таслан зогсоох зорилгоор сэжигтэн гэх нэршлийг эрүүгийн процессын оролцогчоор тооцохоо больсон. Учир нь сэжигтэнд хугацаагүйгээр хилийн хориг тавих, батлан даалт, барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авах, хамгийн ноцтой нь хүнийг зүгээр л сэжиглээд 14 хоног хорьдог, 72 цагтайгаа нийлэх юм бол 17 хоног хорьж саатуулах нөхцөл бүрдсэн байсан.

Тиймээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31-р бүлэгт бүхэлд нь ямар тохиолдолд хүнийг сэжигтнээр дуудах, баривчлахыг нарийвчлан заасан. Гэтэл энэ бүлгийг хэрэглэхийн оронд хүнийг гэрчээр дуудаад өөрийнх нь эсрэг мэдүүлэг авч, улмаар яллагдагчаар татаж байна. Нэг ёсондоо сэжигтнээр оролцох ёстой хүнийг гэрчээр оролцуулсны улмаас Монгол Улсын Үндсэн хуульд заасан гомдол гаргах эрх нь автоматаар хасагдаж байгаа буюу “гэрч” болсноор гомдол гаргах, мөрдөгч, прокуророос татгалзах, өөрөө өөрийгөө өмгөөлөх эрхгүй болж байна. Тэр ч бүү хэл ямар хэрэгт сэжиглэгдэж байгаагаа мэдэх эрхгүй. Мөн ар гэртэйгээ холбоо барих, өмгөөлөгчдөө мэдэгдэх боломжгүй. Харин сэжигтэн байх тохиолдолд эдгээр эрх нээлттэй.

Өмнө нь хангалттай баримт цуглараагүй байхад сэжиг таамаг төдий баримтад үндэслээд эрүүгийн хэрэг үүсгэдэг эрх мөрдөгчид байсан. Үндсэндээ 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн үед бий болсон буруу практикийг халах зорилгоор 31-р бүлгийг оруулж ирсэн. Өөрөөр хэлбэл, яллагдагчаар татах буюу эрүүгийн хэрэг үүсгэх хоёр үе шат салангид байсныг нэгтгэсэн нь тун зөв алхам юм. Энэ нь маш чухал ач холбогдолтой, тухайлбал, хангалттай баримт цуглуулж байж тухайн хүнийг яллагдагчаар татна гэсэн үг. Яллагдагчаар татахаас өмнө тухайн хүний эрхэд халдах эрх хэнд ч байхгүй шүү гэдэг концепцыг хуульд суулгаж өгсөн. Сэжигтэн гэх нэр томъёог ашиглах болсон шаардлага бол хэн нэгэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол гаргаад түүнийгээ танилцуулахаар дуудах хүртэлх хугацаанд л тогтоож байгаа нэршил юм. Энэ хугацаа маш богино, тухайлбал 48 цаг л байна.

Мөн яллагдагчаар татахдаа эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан прокурорын тогтоолыг даруй танилцуулна, 12 цагийн дотор хувийн байдлыг тогтооно гэж хуульд заасан. Гэтэл практикт 3, 5, 7 хоногийн дараа яллагдагчаар татсан тогтоолыг сэжигтэнд танилцуулсан зөрчил их байна. Энэ процессын зөрчлийг шүүхийн шатанд гаргаж тавихаар “Процессын алдаа гарсан байна, шүүхээс буцаах аргагүй” гээд өнгөрүүлдэг. Тиймээс энэ төрлийн зөрчилд ямар арга хэмжээ авахыг тодорхой болгох, цаашлаад мөрдөгчид хариуцлага тооцох асуудлыг хуульчлах шаардлагатай. Тэгэхгүй бол өнөөдөр энэ байдал дахин давтагдаж, хүний эрх хохирсоор байна. Энэ асуудал бол ЭХХШТХ-ийн төдийгүй Үндсэн хууль, олон улсын гэрээг зөрчиж байгаа хэрэг юм.

Монгол Улсын Үндсэн хуульд хүний халдашгүй байх, өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх үндсэн эрхийг баталгаажуулсан. Үүнийг ЭХХШТХ-ийн 1.7-р зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүх прокурор, мөрдөгч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс гэм буруугүй болохыг өөрөөр нь нотлуулахаар, шаардахыг хориглоно” гээд тодорхой заасан. Гэтэл сэжигтнийг баривчилсан тохиолдолд л сэжигтнээр мэдүүлэг авч байгаа болохоос бусад үед гэрчээр мэдүүлэг авч байна. Амьдрал дээр хууль сануулж гэрчээс мэдүүлэг авчхаад дараа нь яллагдагч болгодог процесс бий болжээ.

Сэжигтэнтэй холбоотой хоёр зүйл байна. Нэгдүгээрт, яллагдагчаар татах тогтоол танилцуулахаар хуульд заасан журмын дагуу эрхийн акт үйлдээд дуудсан бол тэр хүн сэжигтэн гэсэн статус руу шууд шилжиж байна гэсэн үг. Ингэснээр сэжигтний эрх, үүрэг бий болно. Хоёрдугаарт, хуульд заасан үндэслэл, журмын

дагуу баривчлагдсан хүнийг сэжигтэн гэнэ. Гэхдээ мэдүүлэг авах нь зөвхөн баривчлагдсан сэжигтэнд л хамаарна. Түүнээс биш яллагдагчаар татах тогтоол танилцуулахаар дуудчихаад сэжигтний мэдүүлэг авна гэж байхгүй. Харин гэрчийн мэдүүлэг авна гэж дуудсан атлаа ирэхээр нь “Сэжигтний мэдүүлэг авна, баривчилна” гэвэл өөр асуудал хөндөгдөнө. Тиймээс ямар зорилгоор дуудаж байгааг анхнаас нь тодорхой болгох зорилгоор прокурорын мэдэгдэх хуудсыг хуульд тусгаж өгсөн. Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөөтэй хүний хувьд мэдэгдэх хуудас ирээгүй тохиолдолд мөрдөгч

Оролцогчийн яриа...

Таван хүн нийлээд нэг газар хоносон, найрласан байж болно. Гэтэл нэг нь нас барчихсан. Хуучин бол дөрвүүлэнг нь сэжигтэн гээд сэжигтний мэдүүлэг авчихаар гэмт хэрэгтэй тэмцэх арга тактик талаасаа мэдүүлгийн ач холбогдол, нотолгооны чадвар сулраад явчихдаг. Тиймээс өөрийг нь энэ хэрэгт холбогдуулж байна гэж үзэх юм бол татгалзаж болно, эсвэл өмгөөлөгч аваад мэдүүлгээ үргэлжлүүлж болно гэдэг процессыг оруулсан.

дуудвал “Уучлаарай, би очихгүй” гэж хэлэх эрх нь нээлттэй.

Гэрчийн мэдүүлэг аваад дараа нь яллагдагчаар татаж байгаа асуудлын цаад, нарийн учгийг ялгаж харах ёстой. Тухайлбал, гэмт хэрэг гарсан эсэх нь тодорхойгүй, гэмт хэргийн шинжтэй, магадгүй хэн үзсэн нь тодорхойгүй тохиолдолд тухайн хүнээс гэрчээр мэдүүлэг авч болно. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг гарсан гэдэг нь цугларсан ямар нэгэн баримтаар тодорхойгүй буюу тухайлж хүн заагаагүй тохиолдолд гэрчээр дуудаж болно. Түүнээс биш “Дорж намайг зодсон” гээд өргөдөл өгөөд байхад Доржийг дуудаад гэрчээр

2. Хойшлуулшгүй тохиолдолд шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан сэжигтнийг 24 цагийн дотор шүүхийн хяналтад хүргэх асуудал

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ

31.5 дугаар зүйл. Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах

1. Мөрдөгч дараах тохиолдолд сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилж болно:

1.1. гэмт хэрэг үйлдэж байх үед, эсхүл үйлдсэн дор нь барьсан;

1.2. энэ хуульд заасан хойшлуулшгүй тохиолдолд;

1.3. гэмт хэрэг үйлдсэн гэж гэрч, хохирогч шууд заасан;

1.4. тухайн хүний хувцас, бие, орон байр, эд зүйл, тээврийн хэрэгсэлд гэмт хэргийн ул мөр илэрсэн.

2. Мөрдөгч сэжигтнийг баривчилсан даруй прокурорт мэдэгдэж, прокурор шийдвэрийг шүүхэд даруй хүргүүлнэ.

3. Мөрдөгч сэжигтнийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу баривчилсан бол 24 цагийн дотор шүүх шийдвэрлэнэ.

4. Мөрдөгч энэ хуулийн 30.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлтэй бол шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналаа сэжигтнийг баривчилснаас хойш прокурорт даруй хүргүүлнэ.

5. Прокурор мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл саналыг хүлээн авснаас хойш 6 цагийн дотор баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах эсэхийг шийдвэрлэнэ.

6. Хууль бусаар баривчлагдсан сэжигтнийг прокурор даруй суллана.

31.6 дугаар зүйл. Баривчилсны дараа хийгдэх ажиллагаа

...

5. Мөрдөгч сэжигтнийг баривчилснаас хойш 6 цагийн дотор тухайн сэжигтнийг баривчилсан талаар түүний гэр бүлийн арван найман насанд хүрсэн гишүүн, эсхүл өмгөөлөгч, гадаад улсын иргэн бол тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэнэ.

асууж болохгүй. Энэ тохиолдолд Үндсэн хууль зөрчинө. Гэмт хэрэг гарсан эсэх, эсвэл хэн үйлдсэн талаар ямар нэг баримт байхгүй үед л гэрчийн мэдүүлэг авна.

Хууль сахиулах үйл ажиллагаа 24 цагийн турш тасралтгүй явагдаж байдаг бөгөөд сэжигтнийг хуульд заасан үндэслэл бүхий үед шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах шаардлага гардаг хэдий ч шөнө, амралтын

Оролцогчийн яриа...

Эрүүгийн хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл, байнгын хороо, чуулганы хуралдааны тэмдэглэлд “зөвшөөрлийн систем шүүхэд шилжлээ, хууль сахиулах ажиллагааны горимд Монгол Улсын шүүх ажиллахад бэлэн үү?” гэсэн асуултад шүүх ажиллаж болно гэсний дагуу энэ чиг үүрэг шүүхэд шилжиж орж ирсэн. Зарим аймгуудад шүүх нь ажиллаж байна. Шүүхийн хэлэлцүүлэг хийгээд тамга тэмдгээ дарж байгаа. Гэтэл зарим нь болохоор болохгүй, тусгай танхим хэрэгтэй, шүүхийн тамга ерөнхий шүүгч, эсвэл туслахад нь байдаг. Тэгэхээр шөнө ерөнхий шүүгч, туслах, нарийн бичгийг сэрээх шаардлага үүснэ гэдэг. Энэ ЭХХШТХ-д шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдаан, шүүхийн хурдан хэлэлцүүлэг гээд гурван өөр төрлийн шүүхийн хэлэлцүүлэг тусгагдсан. Гэтэл Монгол Улсын шүүх хуучин сэтгэлгээгээр хандаж, шүүх хуралдаан шиг хүндрүүлж ойлгоод байна. Энэ бол шуурхай үйл ажиллагаа.

өдрүүдэд шүүх ажилладаггүйн улмаас ЭХХШТХ-ийн 31.5 дугаар зүйлийн 31.5.3-т заасан “24 цагийн дотор шүүх шийдвэрлэнэ” гэсэн заалт хэрэгжихгүй байна. Үүнээс болж практикт хүндрэл учирч, улмаар гэрчээр дуудаж мэдүүлэг авах зэрэг өөр гарц хайхад хүрчээ.

Оролцогчийн яриа...

Өмгөөлөгчдийн хувьд “хар Баасан гараг” гэдэг нэршил байгаа. “Тав дахь өдрийн таван цагт ирээрэй” гэж юу гэсэн үг юм бэ? Нөгөө хүн нь дуудагдахдаа “Очихгүй бол болохгүй, яана?” гэдэг. Бид нар мэддэг учраас “Битгий оч” гэж зөвлөдөг. “Тэр мэдэгдэх хуудсаа танд өгсөн үү?” гэхэд “Үгүй, таван цагт ир гэсэн” гэдэг. Тэгээд таван цагт саяын ярьдаг 48 цагаа бариад явчихдаг. Ялангуяа баривчлагдсан асуудал дээр шүүх шийдвэр гаргах, прокурор шүүхэд хүргүүлэх, мөрдөгч хүргүүлэх, өмгөөлөгчийн талаар 15.2-т заасан “өмгөөлөгч аль ч үе шатанд шүүхэд хүсэлт гаргах” гээд энэ бүх процедурт цаг хугацаа зааж өгөх шаардлагатай. Баривчлагдсан, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан үед өмгөөлөгч хүсэлт өгөхөөр өмгөөлөгчийн хүсэлтийг хэзээ шийдэх нь мэдэгдэхгүй байна. 24 цагийн дотор прокурорын санал ирдэг, 24 цагийн дотор өмгөөлөгч, оролцогчид мэдэгдэнэ гэдэг. Гэтэл мэдэгдээд л болдог. Шүүх хурал хэзээ хийх нь тодорхойгүй. Үүнийг маш сайн журамлаж өгөх нь зүйтэй. Хууль боловсруулах шатанд өмгөөлөгчдийн оролцоо бага байсны улмаас дээрх ажиллагаанууд прокурор, шүүхийн талд байна. Аль аль талд нь тэгш оролцоог хангаж хуульчлах шаардлагатай.

Хуульдаа бол “зургаан цагийн дотор түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн өмгөөлөгчид нь мэдэгдэнэ” гэсэн тов тодорхой зохицуулалт байгаа. Гэтэл амьдрал дээр зургаан цагийн дотор мэдэгдэж байгаа байдал хэдэн хувьтай байна вэ? Энэ өнөөдөр үнэхээр анхаарал татаж байгаа асуудал. Нэг өрөөнд оруулж суулгаад, магадгүй, өглөөнөөс орой болтол байлгаад, орой нь аваачаад хийчихдэг. Ийм тохиолдлууд их байна.

Хойшлуулшгүй тохиолдолд шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах шаардлага гардаг. Тухайлбал, хэргийн халуун мөрөөр орсон үед тухайн хүнийг саатуулж байж, холбогдох нотлох баримтыг бэхжүүлнэ. Энэ тохиолдолд шүүх 24 цагаар ажиллах тухай асуудал яригдаж байна.

3. Хууль зүйн туслалцаа авах эрх

өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, өмгөөлөгч, гэр бүлийн гишүүнтэй холбогдох боломжоор хангагдах;

ЭХХШТХ-ийн 31.8 дугаар зүйл, 1.3

хууль зүйн туслалцаа авах эрхтэй болох;

ЭХХШТХ-ийн 31.6 дугаар зүйл, 1.2

өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч сонгон авах;

ЭХХШТХ-ийн 31.11 дүгээр зүйлийн 1.2

Сэжигтний сонгон авсан өмгөөлөгч 2 цагийн дотор хүрэлцэн ирээгүй, эсхүл өмгөөлөгч авахаас татгалзсан бол энэ хуулийн 5.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу өмгөөлөгч оролцуулна.

ЭХХШТХ-ийн 31.11 дүгээр зүйлийн 3

Мөрдөгч сэжигтнийг баривчилсны дараа 6 цагийн дотор гэр бүлийн гишүүн, өмгөөлөгч, холбогдох талд мэдэгдэхгүй байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 13, 14 дэх хэсгийг зөрчиж буй хэрэг юм. Тиймээс энэ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн ноцтой зөрчил болох бөгөөд Эрүүгийн хуулийн 13.4, 13.9-д заасан гэмт хэргийн шинжийг агуулж байна.

ЭХХШТХ-ийн 31.3 дугаар зүйлийн 4-т “яллагдагчаар мэдүүлэг авах ажиллагааг 12 цагийн дотор явуулна” гэж заасан нь өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхийг зөрчиж байна. Улаанбаатар хотод бол хангалттай тооны өмгөөлөгч байна, харин зарим сумдад гэмт хэрэгт холбогдож, анхны мэдүүлэг өгөх гэж байгаа хүний хувьд өмгөөлөгч байхгүй. Үүнээс үүдэн 200, 300 километр зайтай аймаг руу, эсвэл мянган километр явж нийслэлд ирж өмгөөлөгч авах асуудал хөндөгдөж байна. Тиймээс хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаажуулсан шинэчлэл хийх шаардлагатай. Өнөөдөр Өвөрхангай аймгийн Хархорин, Зүүнхараа зэрэг 10 хүрэхгүй суманд л өмгөөлөгч ажилладаг. Энд гэмт хэрэгт холбогдон дуудагдсан хүн эрхээ яаж хамгаалуулах, хуульд заасан өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авах эрхээ хэрхэн хангах асуудалд хүндрэл учрах болсон. Наад зах нь сумын хэсгийн төлөөлөгчид тайлбар, мэдүүлэг өгөх асуудал гарна. Сэжигтнээс, эсвэл гэрчээс мэдүүлэг авах үед өөрийнх нь эсрэг мэдүүлэг авах гэж байна гэж үзвэл тэмдэглүүлээд, өмгөөлөгчтэй үргэлжлүүлнэ гэсэн зохицуулалт хуульд туссан. Амьдрал дээр энэ хуулийн зохицуулалт хөдөө орон нутагт хэрэгжих бодит боломжгүй байна.

4. Эрүүгийн процесс дахь хяналт, тэнцвэрийн зарчим

Мөрдөгч нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, яллагдагчийг мэдүүлэг авах, шийдвэр танилцуулах, мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулахаар дуудан ирүүлж болно. Мөрдөгчийн дуудсанаар хүрэлцэн ирээгүй нь албадлага хэрэглэх, хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.

ЭХХШТХ-ийн 12.1 дүгээр зүйлийн 1

Мөрдөгч нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, яллагдагчаас мэдүүлэг авах, шийдвэр танилцуулах, мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулах зайлшгүй шаардлагатай бол прокурорын мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлнэ.

ЭХХШТХ-ийн 12.1 дүгээр зүйлийн 2

Прокурор эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэний дараа сэжигтнийг мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлж, уг тогтоолыг танилцуулахыг мөрдөгчид даалгана.

ЭХХШТХ-ийн 31.2 дугаар зүйлийн 2

Энэ хуулиар 1927 оноос хойш мөрдөж ирсэн философийг бүхэлд нь өөрчилсөн. Нэрнээс нь л авч үзье. Тухайлбал, 1927 онд Аливаа хэргийг хэрхэн байцаан шийтгэх тухай хууль, 1935 онд Аливаа эрүүгийн хэргийг хэрхэн байцаан шийтгэх тухай хууль, 1949 онд Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 1963 онд Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002 онд Эрүүгийн байцаан шийтгэх хууль үйлчилж ирсэн. Нэршлээсээ л байцаагаад шийтгэдэг хууль гэдэг нь харагдана. Шинэ хууль бол Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль болж өөрчлөгдсөн. Байцаах гэдэг үг байхгүй болсон, ингэснээр байцаалтад тулгуурлан явуулдаг буюу “Вышинскийн онол” хэмээн нэрлэгддэг, хүнийг дуудаж авчраад, өөрийнх нь мэдүүлэгт үндэслээд ялладаг системийг халсан гэсэн үг юм. Учир нь мэдүүлэг авах процесс бол Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан иргэний чөлөөтэй зорчих, халдашгүй чөлөөтэй байх эрхийг хөнддөг. Тиймээс зөвхөн мэдүүлгээр нотолдог байдлаас салахын тулд нотлох ажиллагааны олон арга хэлбэрийг нэмж хуульчилсан. Мөн мэдүүлгийн нотлохуйц байдлыг дээшлүүлэхийн тулд процессыг нарийн журамлаж өгсөн юм.

ЭХХШТХ-ийн 31.2 дугаар зүйлийн 2-т “Прокурор эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэний дараа сэжигтнийг мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлж, уг тогтоолыг танилцуулахыг мөрдөгчид даалгана” гэсэн зохицуулалт шинээр туссан. Энэ нь сэжигтнийг дуудан ирүүлэхдээ прокурорын мэдэгдэх хуудсаар ирүүлэх бөгөөд ингэснээр мөрдөн шалгах үйл ажиллагааг гардан явуулж байгаа мөрдөгчид дуудан ирүүлэх эрх олголгүйгээр, эрүүгийн процесс дахь хяналт, тэнцвэрийн зарчмыг хангасан хэрэг юм.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт гэсэн хоёр үе шат байгаа. Энэ концепцын дагуу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатыг ЭХХШТХ-аар зохицуулсан. Хэрэг бүртгэлт бол эзэн холбогдогчийг олж тогтооход чиглэсэн үйл ажиллагаа. Мөрдөн байцаалтын ажиллагаа бол яллагдагчаар татаж, яллагдагчийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай эсэхийг нь тогтоох ажиллагаа юм. Яагаад эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг нь прокурор үйлдээд, дуудан ирүүлэх үүргийг нь мөрдөгчид өгч байгаа вэ гэхээр энэ цаг үеэс эхлээд прокурор хэн нэгэн хүнийг яллах ажиллагаагаа эхлүүлж, яллах нотлох баримтуудаа албан ёсоор нөгөө хүндээ мэдэгдэж байгаад цуглуулж байна гэсэн үг. Энэ нь үл ялих сэжиг төдийхнөөр хүнийг дуудан авчирч, удаан хугацаагаар хүлээлгэж залхаадаг байдлыг халах зорилготой.

Мөрдөгч “Ир” гэж дуудахад тухайн хүний Үндсэн хуулиар хамгаалагдсан чөлөөтэй зорчих эрх хөндөгдөнө. Тиймээс хүний эрхэд халдахад шүүх, прокурор зэрэг эрх бүхий албан тушаалтны шийдвэр шаардах болсон. ЭХХШТХ-аар мөрдөгч нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, яллагдагчийг дуудаж болох ч сэжигтнээр дуудах нь энэ хуулиар хориотой. Зөвхөн эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол танилцуулахаар л сэжигтнийг дуудахаар зохицуулсан.

5. Ямар хэрэгт буруутгагдаж байгаагаа мэдэх эрх ба эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хуулбарлан өгөх асуудал

Ямар гэмт хэрэгт сэжиглэж байгаа;

ЭХХШТХ-ийн 31.6 дугаар зүйлийн 1.1

Баривчилсан үндэслэлтэй танилцах;

ЭХХШТХ-ийн 31.8 дугаар зүйлийн 1.1

Баривчлагдсан сэжигтэн түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцах, хуулбарлаж авах, баривчилсан үндэслэлийн талаар мөрдөгчөөр тайлбарлуулах эрхтэй.

ЭХХШТХ-ийн 31.8 дугаар зүйлийн 2

Үндсэн хууль, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад зааснаар ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх эрхтэй. Үүнийг ЭХХШТХ-ийн 31.6, 31.8 дугаар зүйлд заасан. Тухайлбал, 31.8 дугаар зүйлийн 2-т “Баривчлагдсан сэжигтэн, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцаж хуулбарлаж авах, баривчлагдсан үндэслэлийн талаар мөрдөгчөөр тайлбарлуулах эрхтэй” гэсэн процессын хамгаалалт туссан. Гэтэл тус заалтыг зөвхөн “баривчлагдсан” сэжигтэнд хамааралтай, дуудан ирүүлсэн сэжигтэнд хамааралгүй хэмээн гуйвуулж байна.

Оролцогчийн яриа...

Өмгөөллийн үйл ажиллагаа явуулж байхад практикт хамгийн их гарч байгаа том зөрчил бол эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тогтоолыг 3, 5, 7 хоногийн дараа сэжигтэнд танилцуулсан зөрчил юм. Шүүх дээр очоод үүнийг ярихаар “Процессын алдаа гарчээ, буцаалтай нь биш, шийдье” гээд л өнгөрдөг. Магадгүй, ийм зөрчил гаргасан мөрдөгчид хариуцлага тооцох асуудлыг хуульчлах шаардлагатай. Тэгэхгүй бол энэ байдал дахин давтагдсаар, хүний эрх хохирсоор л байна. Ийм тохиолдол миний өмгөөлсөн хэргийн бараг 80, 90 хувьд байгаа.

Тус заалтын “баривчлагдсан” гэсэн үгийг хасах шаардлагатай. Энэ үг хуульд туссанаас болж сэжигтнийг баривчлагдсан, баривчлагдаагүй хэмээн хоёр ялгамжтай үзэхэд хүргэсэн байна. Үүний улмаас баривчлагдаагүй сэжигтэнд тогтоолыг үзүүлэхгүй, хувилж өгдөггүй буруу практик тогтсон. Тиймээс сэжигтнийг яллагдагчаар татсан л бол баривчлагдсан эсэхээс үл хамааран яллагдагчаар татсан тогтоолыг эх хувиар нь өгч байж Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр хамгаалагдсан ямар хэрэгт буруутгагдаж байгаагаа мэдэх, хууль зүйн туслалцаа авах зэрэг эрх нь баталгаажна.

ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

1. Баривчлагдсан сэжигтний ар гэр, холбогдох хүмүүст 6 цагийн дотор мэдэгдэх үүргээ биелүүлээгүй албан тушаалтныг Эрүүгийн хуулийн 13.4-р зүйл буюу Хүнийг хүчээр алга болгох, 13.9-р зүйл буюу Хууль бусаар баривчлах, саатуулах гэмт хэрэгт холбогдуулан шалгаж, хариуцлага хүлээлгэх;
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд туссан шүүхийн зөвшөөрөлтэй холбогдуулан шүүх 24 цаг ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх;
3. ЭХХШтХ-ийн 31 дүгээр бүлэгт заасан зөрчил гаргасан тохиолдолд тус хуулийн 1.13 дугаар зүйлийн дагуу эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандах асуудлыг нарийвчлан зохицуулах;
4. ЭХХШтХ-ийн 31.8 дугаар зүйлийн 2 дахь заалтаас “баривчлагдсан” гэх үгийг хасах, “хуулбарлаж өгөх” биш, “эх хувийг гардуулах” гэсэн өөрчлөлт оруулах;
5. Эрүүгийн процесс дахь хяналт, тэнцвэрийн зарчмыг алдагдуулсан аливаа нэмэлт, өөрчлөлтийг хуульд оруулахаас сэргийлэх;
6. Шударга шүүхээр шүүлгэх эрхийн талаарх сургалтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч бүх талд системтэйгээр зохион байгуулах.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦОГЧДЫН НЭРС

1. Б.Баатарсайхан - МӨХ-ны Удирдах зөвлөлийн дарга, Соёмбо Легал Партнерс ХХН-ийн Гүйцэтгэх захирал, өмгөөлөгч
2. Б.Батаа - Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч
3. Б.Батзориг - Монголын криминологичдын холбооны Удирдах зөвлөлийн дарга, хууль зүйн ухааны доктор (Ph.D), дэд профессор
4. С.Дондов - ХЭҮК-ын гишүүн
5. Г.Наранбаатар - МХХ-ны зөвлөлийн гишүүн, хууль зүйн ухааны доктор (Ph.D), дэд профессор
6. Д.Оросоо - МӨХ-ны гишүүн, өмгөөлөгч
7. Ч.Өнөржаргал - Өмгөөлөгч
8. Ш.Цолмон - ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч

Хэлэлцүүлгийг хөтөлж,
тэмдэглэлийг сийрүүлсэн
Б.ХИШИГСАЙХАН,
ННФ-ын Эрхзүйн хөтөлбөрийн
менежер



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Хаяг: Монгол Улс,
Улаанбаатар хот-14240,
Сүхбаатар дүүрэг,
Жамьян гүний гудамж-5/1

Утас: 976-76113207
Факс: 976-11-324857
Веб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn